



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

“Улаанбаатур” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн хамтран зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16.5, 16.5.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/51 дүгээр захирамж, тус газрын дүрмийн 3.2.4, 3.2.5, 4.6, 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих, дотоод, гадаадад аялагч нийслэлийн иргэдэд аяллын холбогдолтой бүх төрлийн зөвлөгөө, мэдээллийг нэг дороос хүргэх зорилгоор 2016 оны 06 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд “Улаанбаатур” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулсугай.

2. Үзэсгэлэн зохион байгуулахад шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. “Улаанбаатур” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн зохион байгуулалтыг Улаанбаатар аялал жуулчлалын холбоогоор гэрээ байгуулан гүйцэтгүүлж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Н.Алтанзаяад даалгасугай.


4. Үзэсгэлэнд оролцоход шаардагдах төсөв болох 19,400,000 /арван сая, дөрвөн зуу мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 03 сарын 24 өдрийн
тушаалын хавсралт



"УЛААНБААТУР" ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз засал	1	3 000 000	3 000 000
2	Арга хэмжээ болох талбайг тохижуулах	1	1 500 000	1 500 000
3	Майхан түрээс /3x3м ² / /1 өдөр/	100	100 000	10 000 000
4	Сандал /200 ширхэг/, ширээ түрээслэх /100 ширхэг/	300	5 000	1 500 000
5	Цуврал хэвлэлийн мэдээ, шторк хийлгэх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах	1	1 500 000	1 500 000
6	Маркетинг сурталчилгаа хийх, хэвлэлийн зардал	1	1 000 000	1 000 000
7	Туслах ажилчдын хоол унааны зардал	10	40 000	400 000
8	Тээврийн зардал /2 талдаа/	5	100 000	500 000
Дүн				19 400 000